

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
БАГАЧУУД ХУНС ОНӨААТУГ-ЫН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛСАН
ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

№	Удирдах ажилтны хүлээсэн үүрэг	Биелэлт	Хувь
1	Хууль, дүрэм, энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх үүрэг хүлээж, шүүхийн маргаанд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг шүүхэд төлөөлж гарсан үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцна.	Шүүхэд Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийг төлөөлж гарсан маргаан байхгүй.	100%
2	Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	2023 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл дунд хугацааны төлөвлөлтийн зорилт арга хэмжээний биелэлт, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг холбогдох хүснэгтээр хугацаанд нь тайлагнан хургуулна.	100%
3	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэл үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцаж ажиллана.	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хэвийн ажиллагааг ханган ажиллаж байгаа бөгөөд 2023 онд нийт 7,939,370.2 мянган төгрөгийн борлуулалтын орлого олж 7,862,963.18 мянган төгрөгийн зардал гарган 76,907.07 мянган төгрөгийн ашигтай ажлахаар баталсан бөгөөд 2023 оны байдлаар 4,968,358.25 мянган төгрөгийн орлого олж 4,943,358.25 мянган төгрөгийн зардал гарган 25 сая төгрөгийн ашигтай ажилласан урьдчилсан гүйцэтгэлтэй ажиллаж байна.	75%
4	Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд мерит тогтолцоог тууштай хэрэгжүүлнэ.	Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу байгууллагын бүтэц орон тооны дутагдалтай менежер, хуульч, хүний нөөц-1, эрүүл ахуйч-1, захирлын туслах, кассын нярав-1, түгээлтийн нярав-2, жолооч-1, ачигч-4 сул орон тоог тус бүр байгууллагын bagachuidkhuns.ub.gov.mn цахим хуудас болон facebook хаягаар зарлаж, нийт 10 ажилтанг сонгон шалгаруулж ТОМИЛСОН.	100%

5	Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.	Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 13 сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 73 цэцэрлэгийн захиалгын дагуу эрүүл аюулгүй хүнсний бүтээгдэхүүний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй тухай бүрт 119 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэн ажиллаж байна.	100%
6	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан, хэрэгжүүлнэ.	Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд ажилтнуудын цалинг шинэчлэн тогтоох тухай хүсэлтийг Нийслэлийн өмчийн харилцааны газарт 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлж, 2023 оны зорилтод түвшин батлагдаж ажилчдын цалинг 20-35 хувиар нэмсэн. Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, ажлын тусгай хувцас 7 ширхэг, хамгаалах болон үйлчилгээнд шаардагдах хэрэгсэл материалаар тухай бүр хангаж, 2 компьютер, 4 принтерийг нийт 8,919,4 мянган төгрөгөөр шинээр худалдан авч ажилтныг ажиллах нөхцлөөр хангасан. Шинээр орон байранд орсон 1 ажилтанд 1,000,000.00 төгрөг, шинээр хүүхэд мэндэлсэн 1 ажилтанд 500,000.00 төгрөг, 3 ажилтны хүүхдийн сэвлэг үргэх ёслолд 2,000,000.00 төгрөг, 8 ажилчдад түлээ, нүүрсний хөнгөлөлтийг үзүүлж 2,560,000.00 төгрөгийг тус тус олгосон. Нийт ажилтнууд нь удирдах дээд байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулсан 20 удаагийн сургалтанд хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн.	100%
7	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээг авна.	2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл байхгүй. Нийслэлийн өргөдөл гомдлын цахим ер.ulaanbaatar.mn программаар ирсэн ажилтны гаргасан 15 өргөдлийг хүлээн авч, ажилд орох 10, жирэмсний болон амаржсаны амралттай 2, хавсран гүйцэтгэсэн ажлаас чөлөөлөх 1, ажлаас чөлөөлөх 2 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэсэн.	100%
8	Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүргийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлж ажиллана.	2023 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн удирдах ажилтны 34 удаагийн шуурхай зөвлөгөөнд оролцсон. Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд нь хургуулж ажилласан.	100%
9	Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр ханган, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнана.	Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар гаргаж хүргүүлсэн.	100%
	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасны дагуу байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл	2023 оны жилийн эцсийн байдлаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байгууллагын даргын шийдвэрийг	

10	ажиллагаа ил тод, нээлттэй байх бөгөөд холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор UBlegal.uiaanbaatar.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангана.	байгууллагын bagachuudkhuns.ub.gov.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангасан. Цахим хуудас www.bagachuudkhuns.ub.gov.mn-д байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээ, дүрэм, журам, тушаал, шийдвэр, ажлын байрны сул орон тоо, зохион байгуулагдаж буй арга хэмжээний мэдээлэл зэргийг байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. Bagachuudkhuns.ub.gov.mn цахим хуудсанд шинээр үйл явдлын мэдээ 27 мэдээллийг нийтэлж, давхардсан тоогоор 18780 хүнд хүргэсэн. Фейсбүүк пэйж хуудсанд шинээр үйл явдлын мэдээ 6, гэрэл зураг 16 мэдээллийг нийтэлж, давхардсан тоогоор 5009 хүнд хүргэсэн. Албан тушаалын сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас, пэйж хуудсаар дамжуулан нийт 3 удаа байршуулан, 10 ажилтныг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сонгон шалгаруулж ажилд авсан. UBlegal.uiaanbaatar.mn цахим хуудаст нэвтрэх эрх байхгүй болно.	100%
11	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллана.	Нийтийн мэдээллийн ил тод байлгах хуулийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын шилэн дансны хөтлөлтөд 2023 оны 1-11 дүгээр саруудын 5,000,000.00 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого болон зарлагын гүйлгээ гарсан тухай бүрд нь холбогдох мэдээллийг хугацаанд нь оруулж тайлагнасан. 2023 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгасан 21 багцаас 12 багцад 14 аж ахуйн нэгж байгууллага тендерийн баримт бичиг ирүүлсэн бөгөөд 9 багцад огт тендерийн материалыг ирээгүй болно. 12 багцад ирүүлсэн тендерийн баримт бичгийг үнэлж үзээд 5 аж ахуйн нэгж байгууллагад гэрээ байгуулах эрх олгож гэрээг байгуулан ажиллаж байна. 16 ажлаас төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудсаар 2 дахь тендерийг 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зарласан ба 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдөр тендерийг нээж хийж, нийт 16 багц шалгаруулахаас тендерийн материал ирүүлсэн 5 багцад хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн хонь, үхрийн маханд "Хулагу холдинг" ХХК, нарийн бүүдүүн ногоонд "Эрдэнэ энх" ХХК, цагаан идээнд "Ану-Нинж" ХХК нь хамгийн сайн тендерээр үнэлэгдэн шалгарсан. Шалгараагүй 11 багцад шууд гэрээ байгуулан ажиллахыг үнэлгээний хорооноос зөвлөмжөөр хүргүүлсний дагуу шууд гэрээ байгуулан, мөн түргэн гэмтэх бүтээгдэхүүн болох сүү сүүн бүтээгдэхүүнийг худалдах худалдан авах гэрээний дагуу "Агу	100%

12	<p>Хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоол, 2020 оны "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" батлах тухай 217 дугаар тогтоол, 2020 оны "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мөргөшлийн түвшинг үнэлэх журам" батлах тухай 218 дугаар тогтоол, 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоол, 2021 оны "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах" тухай 360 дугаар тогтоол, 2022 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 430 дугаар тогтоол, 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.</p>	<p>дейри" ХХК-аас шууд түгээлгэж, талх, талхан бүтээгдэхүүнийг "Талх чихэр" ХХК-тай хийсэн гурвалсан гэрээний дагуу үйлдвэрээс шууд түгээлгэн, хөндлөнгийн хяналтыг хийн ажиллаж байна.</p>	
13	<p>Улаанбаатар хотын ерөнхий менежерийн баталсан 2023 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах хуваарь батлах тухай" А/01 дүгээр тушаал, их цэвэрлэгээний хуваарийн дагуу 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр, "Их цэвэрлэгээ 90 минут", 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр "Хоггүй шинэлье", 04 дүгээр сарын 14-ний өдөр "Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ", 05 дугаар сарын 12-ны өдөр "Хотоо угаая", 05 дугаар сарын 26-ны өдөр "Хүүхдийн баярыг угтсан их цэвэрлэгээ"-г хийн байгууллагын гаднах орчны 50 метр хүртэлх зам талбайн хог, хаягдал, цас, мөсийг цэвэрлэсэн. 8 дугаар 01-ны өдрөөс 12 дугаар сарын 11-ний өдөр хүртэл 5 удаа байгууллагын гадна 50м нийтийн эзэмшлийн талбайг. 10 дугаар</p>	<p>Холбогдох хууль тогтоомжийг байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөгө болгон ажиллаж байна. Монгол улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох" тухай 62 дугаар тогтоолын хүрээнд манай байгууллага цахилгаанаар дулааны холболтыг шийдвэрлэсэн тул нүүрс хэрэглэдэггүй. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 01 дүгээр сард НЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтсээр хянуулж батлуулсан. Байгууллагын 16 ажилтан жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулж хагас жилээр ажлын тайланг хянуулж ажилласан. "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 448 дугаар тогтоол, 2021 оны "Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 388 дугаар тогтоолыг мөрдөж байна. Байгууллагаас хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайлан мэдээг 2020 оны "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" батлах тухай 206 дугаар тогтоол, 2021 оны "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 374 дүгээр тогтоолуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.</p>	<p>100%</p>

	<p>Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллана.</p>	<p>сарын 10-ны өдөр жигүүр грандын автобусны буудлаас энх тайваны гүүр хүртэлх замыг цэвэрлэсэн. Их цэвэрлэгээний ажилд байгууллагын 18 ажилтан хамрагдаж гарсан хог хаягдлыг шуудайднд хийж зориулалтын хогийн саванд хийн ачуулж ажиллаа.</p>	<p>Жилийн эцсийн байдлаар зөвшилцөн ажилласан ажил байхгүй байна.</p>	100%
14				

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
БАГАЧУУД ХҮНС ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ



Б.МӨНХНАСАН